

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 132 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 640 дүгээр тогтоолын хоёрдугаар заалтад “Баталсан тарифыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Дархан-Уул аймгийн Дархан сумын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай” гэснийг “Баталсан тарифыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Дархан-Уул аймгийн Дархан сумын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай” гэж, дөрөвдүгээр заалтад “Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 518 дугаар тогтоол, 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 720 дугаар тогтоолыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн тус тус хүчингүй болгосугай” гэснийг “Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 518 дугаар тогтоол, 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 720 дугаар тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болгосугай” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ